# ХЭНТИЙ АЙМГИЙН
# БАЯН-АДАРГА СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
# ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 19 өдөр    Дугаар А/67    Баян-Адарга сум

Ажлын хэсэг томилон ажиллуулах тухай

Монгол Улсын "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль"-ийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Соёлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1 дэх заалт, "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар бүлгийн 2.1.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол хатдын 3 дугаар наадмыг 2025 оны 08 дугаар сарын 08-09-ны Баян-Адарга сум төв, Монгол хатдын өргөө цогцолборт түшиглэн зохион байгуулсугай.

2. Наадмыг зохион байгуулах Ажлын хэсгийг хавсралтад дурьдсан бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, ажиллуулсугай.

3. Наадмыг зохион байгуулах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, 2 сая төгрөгийн зардлыг Засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас санхүүжүүлэхийг Нягтлан бодогч (Г.Бишүүгармаа)-д зөвшөөрсүгэй.

4. Наадмын хөтөлбөрийг боловсруулан олон нийтэд түгээж, үйл ажиллагааны бэлтгэл ажлыг сайтар төлөвлөн, санхүүжилт хөрөнгө босгох талаар санаачлага гарган ажиллаж, үр дүнг 2025 оны 08 дугаар сарын 18-ны дотор сумын Засаг даргын Зөвлөлд тайлагнахыг Ажлын хэсгийн ахлагч, сумын Засаг даргын Тамгын газрын дарга (С.Бат-Эрдэнэ), Монгол хатдын өргөө цогцолборын Захирал, ажлын хэсгийн нарийн бичгийн дарга (С.Оюунтуяа) нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА    С.ЛХАГВАДОРЖ

Сумын Засаг даргын
2025 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн
А/64 дугаар Захирамжийн хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

| | |
|---|---|
| Ажлын хэсгийн ахлагч | С.Бат-Эрдэнэ Сумын Засаг даргын Тамгын газрын дарга |
| Гишүүн | Л.Бат-Октябрь Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгч, аймгийн Нутгийн Зөвлөлийн дарга |
| Гишүүн | Г.Хонгорзул Улаанбаатар хотын Нутгийн зөвлөлийн дарга |
| Гишүүн | М.Нямдорж Дуурлиг багийн Засаг дарга |
| Гишүүн | Г.Гимаа Нийгмийн бодлогын мэргэжилтэн |
| Гишүүн | М.Отгонжаргал Ерөнхий Боловсролын Сургуулийн Нийгмийн ажилтан |
| Гишүүн | Э.Баднаагарав иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгч |
| Гишүүн | |
| Гишүүн | М.Мөнхбат Хүнчин богд ХХК-ийн Захирал |
| Гишүүн | Ц.Майдэлгэр Иргэн |
| Нарийн бичгийн дарга | С.Оюунтуяа Монгол хатдын өргөө цогцолборын дарга |